

ДОРНОД АЙМГИЙН 2017 ОНЫ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018.01.15

Чойбалсан хот



Өрх, хүн ам: 2017 оны жилийн эцсийн байдлаар 14 сумын 66 багт 24.0 мянган өрхөд 79.5 мянган хүн амьдарч байгаагийн 56.3 хувь нь аймгийн төвд, 17.3 хувь нь сумын төвд, 26.4 хувь нь хөдөө амьдарч байна.

2017 оны нийт хүн амын тоог 2016 оны хүн амын тоотой харьцуулж үзвэл 1735 хүнээр буюу 2.2 хувиар, өрхийн хувьд 734 өрхөөр буюу 3.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Хэрлэн сум 45352 хүн ам тоолуулсан нь аймгийн нийт хүн амын 57.0 хувийг эзэлж байна. 3000-аас дээш хүн амтай Баяндун, Баян-Уул, Дашбалбар, Халхгол, Цагаан-овоо, нийт 5 сум байгаа юм.



Аймгийн хэмжээнд 2017 оны 12 сарын байдлаар 1922 эх амаржиж, 1934 хүүхэд төрж, нас баралт 430 болж өмнөх оны мөн үеэс амаржсан эх 145 (7.0%)-аар, төрсөн хүүхэд 142 (6.8%)-аар, нас баралт 87 (16.8%)-аар тус тус буурчээ.

1000 хүнд ногдох төрөлт 25.08, нас баралт 5.58, ердийн цэвэр өсөлт 19.5 болов.

Зураг. I Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2013-2017 оны 12 сард





Эрүүл мэнд: 2017 оны жилийн эцсийн байдлаар 1922 эх амаржиж, нийт нас баралт 430 тохиолдол бүртгэгдсэн. Нас баралтын шалтгааныг төрлөөр нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 134 тохиолдол бүртгэгдсэн ба нийт нас баралтын 31.2%, осол гэмтлийн нас баралт 59 тохиолдол буюу 13.7%-ийг тус тус эзэлж байна.

Хүн амын дотор өвчлөл 39.7 мянган тохиолдол бүртгэгдэж, 143.8 мянган ор хоног ашиглажээ. Амбулаториор 392,4 мянган хүэд үзлэг хийж, эмнэлэгт 19.0 мянган хүнийг хэвтүүлэн эмчилжээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2017 оны 12 сард 2915 болж, өмнөх оны мөн үеийнхээс 337 хүн буюу 13.0 хувиар өсөхөд салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 652 (22.4%), заг хүйтэн өвчнөөр 828 (28.4%) тохиолдол, трихоминиаз 498 (17.0%) тохиолдол тус тус бүртгэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хувийн хэвшлийн эмнэлэг эмийн сангууд 340.7 мянган хүнд үйлчилж, 2511.2 сая төгрөгийн орлоготой ажиллалаа.



Боловсрол: Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуулийн 543 бүлэгт 14.9 мянган хүүхэд суралцаж байна. Дотуур байранд амьдрах хүсэлтийг 844 хүүхэд гаргаснаас 917 хүүхэд амьдарч байна.

Ерөнхий боловсролын 26 сургуульд 791 багш, 37 цэцэрлэгийн 227 бүлэгт 6.8 мянган хүүхэд хүмүүжиж, 430 үндсэн болон туслах багш ажиллаж байна.



Санхүү, төсөв: Орон нутгийн төсвийн нийт орлого 52336.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 55038.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 2702.0 сая төгрөгөөр төлөвлөгөө давсан байна. Татварын орлого 15799.8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 18353.6 сая төгрөгт хүрч 2553.8 сая төгрөгөөр төлөвлөгөө давуулан биелсэн. Татварын бус орлого 36536.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 36684.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 148.2 сая төгрөгөөр давсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 56458.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 55542.7 сая төгрөгийн санхүүжилт хийсэн. Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 3534.1 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 30133.7 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.



Хөдөө аж ахуй: 2017 оны жилийн эцсийн мал тооллогоор 2057.8 мянган толгой мал тоологдсон ба үүнээс тэмээ 5.6 мянга, адуу 250.7 мянга, үхэр 207.8 мянга, хонь 1001.6 мянга, ямаа 592.0 мянга тус тус тоологдов.

Нийт малын тоо өмнөх оноос 334898 толгойгоор өссөн ба 5 төрлөөр нь авч үзвэл өмнөх оноос тэмээ 396, адуу 25726, үхэр 32311, хонь 170210, ямаа 106255 толгойгоор тус тус өссөн байна.

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр хамгийн олон малтай Дашбалбар сум 255412 толгой мал тоолуулсан бол хамгийн бага малтай Халхгол сум 66923 толгой мал тоолуулсан байна.

Тайлант онд Дашбалбар, Халхгол, Чулуунхороот, Хэрлэн сумдаас бусад 10 сум малаа 5 төрөл дээрээ өсгөсөн байна.

Хээлтэгч малын тоо 203.0 мянган толгойгоор өмнөх оныхоос өсч, хээлтэгч мал 931187 толгой болсон байна.

Нийт малын 97.3 хувь нь буюу 2001.9 мянган толгой мал амины аж ахуйд тоологдсон бол 2.7 хувь нь албан газар аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа юм.

Малтай өрхийн тоо 7044 болж өмнөх оноос 6.1 хувиар, малчин өрхийн тоо 5028 болж өмнөх оноос 14.3 хувиар тус тус өссөн байна.

Таван зуугаас дээш малтай айл өрхийн тоо 1133 болсны дотор 365 айл өрх нь 1000-аас дээш малтай болжээ. Таван зуугаас дээш малтай өрхийн тоо өмнөх оныхоос 26.3 хувь буюу 236 өрхөөр 1000-аас дээш малтай өрхийн тоо 52.7 хувиар буюу 126 айл өрхөөр тус тус өссөн байна.

Мал бүхий иргэд, малчид 2017 онд 657.2 мянган төл бойжуулж, бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 81.7 мянган толгойгоор өссөн.

Том малын зүй бусын хорогдол 9.1 мянгад хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 33.1 хувиар буюу 4504 толгойгоор буурсан байна.

Жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор гахай 542 болж 3.8 хувиар өсч, шувуу 13906 болж 12.5 хувиар, бүл зөгий 887 болж 19.5 хувиар тус тус буурсан байна.

Нар салхины болон бусад цахилгааны эх үүсвэртэй өрх 3496, телевизортой өрх 2936, автомашинтай өрх 2466, мотоциклтой өрх 1516, трактортой өрх 268 болсон байна.

Малгүй айл өрхийг малжуулах арга хэмжээний хүрээнд төсөл болон орон нутгийн санхүүжилтээр 518.4 сая төгрөг зарцуулж 138 айл өрхийг 7.0 мянган толгой малтай болголоо. Энэ онд шинээр 111 худаг гаргаж, 53 худаг засварлажээ.

Худаг шинээр гаргахад улсын төсөв, төсөл болон малчдаас 707.0 сая, засварлахад төсөв, төсөл болон иргэдээс 55.0 сая төгрөг зарцуулсан байна.

2017 онд 17012 га-д улаан буудай, 183.4 га-д төмс, 96.9 га-д хүнсний ногоо тариалж, 3515 тн улаан буудай, 1295.9 тн төмс, 641.7 тн хүнсний ногоог тус тус хураан авлаа.

Мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд 62.6 мянган тн хадлан бэлтгэлээ.



Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 57.6 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.7 тэрбум төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан бол оны үнээр 56.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 0.9 тэрбум төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

Энэ онд гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс 526.4 мянган тонн нүүрс олборлож, 252212.7 мянган.квт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 269557 г.кал дулаан нийлүүлж, 3183.8 тн гурил, 1708.4 тн хивэг, 666.7 тн талх, нарийн боов, 5.1 мян.л дарс, 145.2 мян.ширхэг зайрмаг, 8.8 тн хиам, банш бууз тус тус үйлдвэрлэсэн байна.




Тээвэр, харилцаа, холбоо:

Аймгийн Холбооны салбарын нийт орлого 368.6 сая төгрөгт хүрсний 17.1 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байна.

Шуудан тээврийн газар 392 зорчигч тээвэрлэж, 138.7 мянган хүн км-ийн зорчигч эргэлтийн ажил гүйцэтгэн, 60.4 сая төгрөгийн орлого, авто тээврийн төв 39.9 мянган зорчигч тээвэрлэж, 25698.7 мянган хүн км-ийн зорчигч эргэлтийн ажил гүйцэтгэн 101900.4 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ.

Зураг. II Тээсэн зорчигчдын тоо, мянган хүн, жил бүрийн 12 сарын байдлаар



Барилга, нийтийн аж ахуй: 2017 онд нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллагын нийт орлого 3146.8 сая төгрөгт хүрснээс ус борлуулалтын орлого 1138.7 сая төгрөг буюу 36.1 хувийг эзэлж байна.

Дорнод аймгийн хэмжээнд энэ онд барилга угсралт, их засвар, замын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй аж ахуйн нэгж байгууллага төрийн болон хувийн хөрөнгөөр 11601.8 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.



Хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо эхний 12 сарын байдлаар 1720 байгаагийн 721 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 95 хүнээр буюу 5.2 хувиар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 721 хүн буюу 41.9 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа ба өмнөх оны мөн үеийнхээс 90 хүн буюу 11.1 хувиар буурсан байна. 2017 оны 12 сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст 1554 иргэн ажилд зуучлагдан оржээ.

Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 54.4 хувь нь 15-34 насны залуучууд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 20.0 хувь нь дээд, 6.0 хувь нь тусгай дунд, 8.9 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 52.7 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь суурь, 3.0 хувь нь бага боловсролтой, 1.7 хувь нь боловсролгүй хүмүүс байна.



Гэмт хэрэг: Энэ оны эхний 12 сард 582 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 31 хүн нас барж, 254 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 100 хэргээр буюу 20.7 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд 3262.9 сая төгрөгийн хохирол учирсны 15.7 хувь буюу 512.2 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна. Нийт гарсан гэмт хэргийн 133 хэргийг 158 хүн согтуугаар үйлдсэн байна.

Үйлдэгдсэн бүх хэргийн 193 буюу 33.1 хувь нь хулгайн хэрэг, үүнээс малын хулгайн хэрэг 58 буюу 30.0 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд 50.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 26.9 пунктээр өссөн байна.



Хэрэглээний үнэ: Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2017 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 5.0 хувиар өслөө. **Ерөнхий индекс 2017 оны 12 сард өмнөх сараас 0.1 хувиар** өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг, гэр ахуйн тавилга, амралт, чөлөөт цаг, соёлын үйлчилгээний бүлгийн үнэ тус тус өссөн нь нөлөөлжээ.

**Нийгмийн даатгал, халамж:**

Нийгмийн даатгалын сангаас 2017 онд тэтгэвэр, тэтгэмж олгоход нийт 41596.39 сая төгрөгийг зарцуулжээ. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 11514 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна. Тэтгэвэр тэтгэмжийн сангаас хөдөлмөрийн чадвар түр алдасны тэтгэмжийг 2650 хүнд 282.5 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 1417 хүнд 1295.2 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжийг 419 хүнд 500.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсээс 22 нэр төрлийн үйлчилгээг 22353 иргэнд үзүүлсэн байна.

**Мөнгө, банк:**

Дорнод аймгийн хэмжээнд 2017 онд нийт 134823.8 сая төгрөгийн зээлийн үдэгдэлтэй, хугацаа хэтэрсэн зээл 2184.61 сая, чанаргүй зээл 6232.32 сая төгрөг байна. Хугацаатай хадгаламжинд 42205,49 сая төгрөг, хугацаагүй хадгаламжинд 17927.86 сая төгрөг, харилцах дансанд 53740.8 сая төгрөг тус тус хадгалуулсан байна.

**Худалдан авах ажиллагааны мэдээлэл:**

Орон нутгийн өмчийн газар нь зохион байгуулах төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд нийт 3.9 тэрбум төгрөгийн 85 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан.

**Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан
төсөл, арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэрээр**

Санхүүжилтийн эх үүсвэр	2014 он		2015 он		2016 он		2017 он	
	Дүн /тэрбум төгрөг/	Тоо	Дүн /тэрбум төгрөг/	Тоо	Дүн /тэрбум төгрөг/	Тоо	Дүн /тэрбум төгрөг/	Тоо
Улсын төсөв	8,4	20	0,2	3	0,2	3	0,9	15
Орон нутгийн төсөв	1,5	32	1,9	58	1,5	29	1,4	35
Орон нутгийн хөгжлийн сан	4,7	37	2,2	21	1,6	16	0,8	13
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	0,7	9	0,4	12	0,5	19	0,7	22
БҮГД	15,8	103	4,8	94	3,9	67	3,9	85

Улсын төсвийн хөрөнгөөр 910.8 сая төгрөгийн 15, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1.4 тэрбум төгрөгийн 35, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 0.8 тэрбум төгрөгийн 13, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 755.5 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ байна. Энэ нь өмнөх оны төлөвлөсөн ажлаас 18 төсөл, арга хэмжээгээр их байна.